



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025. 01. 23 № 37-1/18  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРЭНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



000254000866



Г УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БААСАНДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 01. 23 № Удг/224  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай Г

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай  
хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн  
мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 35 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ

000255000412

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 4 дүгээр тэмдэглэлд:

“6.ХЭЛЭЛЦСЭН нь: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



БАТЛАВ.


ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

  
Ж.ЭНХБАЯР

БАТЛАВ.

САНГИЙН САЙД  
  
Д. Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД  
  
Д.АЛТАНГЭРЭЛ

## ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

#### 1.1.Хууль зүйн үндэслэл

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.10-т “хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг” гэж заасан бөгөөд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах нь хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол үйл ажиллагаа юм.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн тогтвортжуулах татварын орчныг Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тогтоох, чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг Чөлөөт бүсийн тухай хуулиар тогтоож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг татварын холбогдох хуулиар зохицуулахаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй” гэж заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.1-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 3.4.2.3-т “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшигийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.” гэж тус тус заасан.

#### 1.2.Практик шаардлага

Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх,



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД


Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2025.01.20 № 01/553

танай 2025.01.10-ны № 01/133-т

### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД Ж.ЭНХБАЯР ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зорилборол огтолж байна.



Б.ЖАВХЛАН

9761000197



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.01.22 № 1/428  
тнай —ны № -т

### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД Ж.ЭНХБАЯР ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



151600446  
Альбатрия 2025

нийлүүлэлтийг тасалдуулахгүй байж, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг эцэслэн баталсан.

Тус хуулиар стратегийн хүнсний нэг болох улаанбуудайн дээд болон I зэргийн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлж, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурилын жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу "Жагсаалт батлах тухай" 180 дугаар тогтоолоор баталсан.

Гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, нөөцийг харгалзан жилийн нийт хэрэгцээний 10 хүртэл хувь буюу 25.0 мян.тн улаанбуудайн гурилыг Монгол Улсын хилийн боомт бүхий аймгуудаар гаалийн албан татваргүй импортлохоор тооцоо судалгааг хийсэн.

Гэвч Монгол Улсын Их хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан хуулиар гурилын импортын гаалийн албан татварыг чөлөөлсөнтэй холбоотой хилийн боомтуудаар орж ирж байгаа гурилын хэмжээ эрс нэмэгдэж жилийн эцсийн байдлаар нийт 64.2 мян.тн улаанбуудайн гурил импортолсон байгаа нь анх тооцоолсноос дариу 3 дахин их гүйцэтгэлтэй байна.

Үүнээс: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтоор 35.9 мян.тн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор 14.1 мян.тн, Увс аймгийн Боршоо боомтоор 10.3 мян.тн, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт, Завхан аймгийн Арцсуурь боомтоор 3.9 мян.тн улаанбуудайн гурилыг Оросын Холбооны Улсаас тус тус имортолсон ба эдгээрийн 40.4 мян.тн нь улаанбуудайн дээд гурил, 23.8 мян.тн нь улаанбуудайн I зэргийн гурил байна.

Хуулийн хугацааг мөрдөж эхлэхээс өмнө буюу 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн статистик мэдээгээр улаанбуудайн 1 кг-аар савласан дээд гурилын үнэ 2969 төгрөг, I зэргийн гурил 2426 төгрөг байсан ба 2024 оны 12 дугаар сарын байдлаар дээд гурил 3207 төгрөг, I зэргийн гурил 2323 төгрөг буюу дотоодын үйлдвэрийн гурилын үнэ буураагүй байна.

Монгол Улсын жишсэн хүн амын тоо 2024\* онд 2.799.2 мянга болно гэж тооцвол 106.3 мян.тн гурил, 191.3 мян.тн гурилан бүтээгдэхүүн хэрэгцээтэй бөгөөд нийт хүн амын хэрэгцээнд 240.0 мян.тн гурил буюу 320.0 мян.тн улаанбуудай шаардлагатай байна.

Улсын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж буй 9 гурилын үйлдвэрийн агуулахад шинэ ургацаас 160.0 мянган тн улаанбуудай, 22.0 мянган тн гурил буюу жишсэн хүн амын 170 хоногийн хэрэглээ хадгалагдаж байна.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй гурилын үйлдвэрүүд суурилагдсан хүчин чадлын 30 хувийг ашиглаж байгаа ба бүрэн хүчин чадлаар ажилбал жилд 300 гаруй мян.тн гурил экспортлох боломжтой юм.

Нийт нутгийн 80 гаруй хувьд нь цасан бүрхүүл тогтох ихэнх нутгаар хүйтний эрч чангарч, мал аж ахуйн салбарын хаваржилт хүндэрч, мал сүрэг өвс тэжээлийн дутагдалд орж, малчид ихээхэн хохирол амсах эрсдэл үүсээд байсан цаг үед хаваржилтыг хохирол багатай даван туулахад малын өвс, тэжээлийн

нөөц хангамжийг нэмэгдүүлэх, орон нутагт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, доройтож тэжээлийн дутагдалд орсон малыг хурдан тэнхрүүлэх зорилгоор өвс, хивэг, овьёс, арвай, хөх тариа, эрдэнэшиш, багсармал хорголжин тэжээл, тэжээлийн нэмэлтийг импортын гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулахад шаардлагатай нийт тэжээлийн 55 орчим хувийг дотооддоо үйлдвэрлэн нийлүүлж, үлдсэн хэсгийг импортоор авахаар тооцоо, судалгааг хийсэн ба мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлснөөр Монгол Улсын хилээр 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 117.9 мян.тн буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэг дахин их мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг импортолсон байна.

Иймд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан хууль зорилгодоо хүрсэн гэж үзэж буй учир Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг хоёр зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсон тухай, 2 дугаар зүйлд хуулийн дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна.

Газар тариалангийн салбар, гурилын үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, стратегийн хүнсний нөөцийг дотоодын үйлдвэрлэлээр хангах нөхцөл бүрдэнэ.

**Дөрөв.Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах хууль байхгүй.

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.1-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 3.4.2.3-т “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.” гэж тус тус заасныг хэрэгжүүлэхээр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хууль хүчингүй болсон тооцох тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан болно.

Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй, тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан.

Хуулийн хүрээнд гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурилын жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоолыг баталсан бөгөөд стратегийн ач холбогдолтой хүнс болох 1101.00.11, 1101.00.12 БТКУС-ийн кодтой улаанбуудайн дээд болон нэгдүгээр зэргийн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Улаанбуудайн гурилын хувьд:

Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан хуулиар гурилын импортын гаалийн албан татварыг чөлөөлсөнтэй холбоотой хилийн боомтуудаар орж ирж байгаа гурилын хэмжээ эрс нэмэгдэж 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 64.2 мян.тн улаанбуудайн гурил импортолсон байгаа нь анх тооцоолсноос дариу 3 дахин их гүйцэтгэлтэй байна.

Гурилыг хилий 8 боомтоор импортолсон бөгөөд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтоор 35.9 мян.тн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор 14.1 мян.тн, Увс аймгийн Боршоо боомтоор 10.3 мян.тн улаанбуудайн гурилыг Оросын Холбооны Улсаас тус тус импортолсон бөгөөд эдгээрийн 40.4 мян.тн нь улаанбуудайн дээд гурил, 23.8 мян.тн нь улаанбуудайн I зэргийн гурил байна.

Монгол Улсын жишсэн хүн амын тоо 2024 онд 2.799.2 мянга болно гэж тооцвол 106.3 мян.тн гурил, 191.3 мян.тн гурилан бүтээгдэхүүн хэрэгцээтэй бөгөөд нийт хүн

амын хэрэгцээнд 238.0 мян.тн гурил буюу 320.0 мян.тн улаанбуудай шаардлагатай байна.

Намрын ургац хураалтын дүнгээр буюу 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар шинэ ургацаас гурилын үйлдвэрүүд 160.8 мянган тонн, Хөдөө аж ахуйг дэмжих сан 46.3 мянган тонн, нийтдээ гурил үйлдвэрлэлд 207.6 мянган тонн хүнсний улаанбуудай хүлээн авсан.

Улсын хэмжээнд 940 мянган тонн үр тариа тээрэмдэх суурилагдсан хүчин чадал бүхий 58 гурилын үйлдвэр, цех байгаагаас 9 нь тогтмол үйл ажиллагаа явуулж, нийт хүчин чадлын 30 хувийг ашиглан 2024 онд 148.4 мянган тонн гурил үйлдвэрлэж, гурилын хэрэгцээний 59.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 40.9 хувийг импортоор хангасан байна.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа гурилын үйлдвэрүүд суурилагдсан хүчин чадлын 30 хувийг ашиглаж байгаа бөгөөд бүрэн хүчин чадлаар ажилласан нөхцөлд жилд 300 гаруй мянган тонн гурил экспортлох боломжтой байна.

Малын тэжээл, тэжээлийн нэмэлтийн хувьд:

Нийт нутгийн 80 гаруй хувьд цасан бүрхүүл тогтох, ихэнх нутгаар хүйтний эрч чангарч, мал аж ахуйн салбарын хаваржилт хүндэрч, мал, сүрэг өвс, тэжээлийн дутагдалд орж, малчид ихээхэн хохирол амсах эрсдэл үүсээд байсан цаг үед хаваржилтыг хохирол багатай даван туулахад малын өвс, тэжээлийн нөөц хангамжийг нэмэгдүүлэх, орон нутагт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, дорийтож тэжээлийн дутагдалд орсон малыг хурдан тэнхрүүлэх зорилгоор өвс, хивэг, овьёос, арвай, хөх тариа, эрдэнэшиш, багсармал хорголжин тэжээл, тэжээлийн нэмэлтийг импортын гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулахад шаардлагатай нийт тэжээлийн 55 орчим хувийг дотооддоо үйлдвэрлэн нийлүүлж, үлдсэн хувийг импортоор авахаар тооцоо, судалгаа хийсэн бөгөөд мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлснөөр Монгол Улсын хилээр 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 117.9 мянга буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 дахин их мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг импортолсон байна.

Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас нийт 18 аймгийн 172 суманд бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөц дуусаж байгаатай холбоотой хивэг, овьёос, хорголжин, багсармал тэжээл болон мал, амьтны тэжээлийн нэмэлт болох эрдэс, уургийн нэмэгдлийг гаалийн албан татвараас чөлөөлснөөр өвөлжилтийн хүндрэлтэй нөхцөл байдлыг хохирол багатай даван туулсан байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хэрэгжсэнээр анх тооцоолсноос дариу 2-3 дахин илүү гүйцэтгэлтэй, тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа гурилын үйлдвэрийн улаанбуудайн үлдэгдэл их, гурил үйлдвэрлэлийн хэмжээ 28 хувь буурах урьдчилсан тооцоолол гарсан бөгөөд гурил болон гурилан бүтээгдэхүүний үнэ буурах нөлөөлөл байхгүй. Түүнчлэн Оросын Холбооны Улсаас импортоор авч байгаа зарим гурилын чанар хангалттай түвшинд хүрэхгүй, малын тэжээлийн нөөцийг дотоодын үйлдвэрлэлээр бэлтгэх бололцоотой зэргийг харгалзан үзэж

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга:

Улсын Их хурлаас баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 3 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөж эхлэх хугацааг заасан хэдий ч дуусгавар болгох хугацаа тодорхойгүй байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон баяжуулсан гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан хууль зорилгодоо хүрсэн гэж үзэж буй учир хуулийн үйлчлэх хугацааг тодорхой болгох зорилгоор Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгасан болно.

Хуулийн төслийг хоёр зүйлтэй байхаар боловсруулж, хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцохоор, 2 дугаар зүйлд хуулийн дагаж мөрдөх хугацааг тус тус тусгалаа.

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:

Шинэ ургацын улаанбуудай хурааж авах улиралтай холбогдуулан 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд газар тариалангийн салбарын холбоодын төлөөлөлттэй санал солилцох уулзалт зохион байгуулсан байна.

Тус уулзалтын үеэр дээрх хуулийн хэрэгжилтийн хүрээнд тухайн өдрийн байдлаар 37.6 мян.тн улаанбуудайн гурил импортолж цаашид ч их хэмжээгээр орж ирэх хандлагатай байгаа нь цаашид улаанбуудайн тариалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй талаар холбооны гишүүд саналаа хэлжээ.

Мөн Дархан-Уул аймагт 2024 оны 08 дугаар сарын 25-ны өдөр газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 30 гаруй аж ахуй нэгжийн төлөөлөлтэй уулзаж ургац хураалт, техникийн шинэчлэл болон “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд малчдын бэлтгэж байгаа өвс, тэжээлийн бэлтгэлийг эрчимжүүлэх өргөн асуудлын хүрээнд хэлэлцүүлэг хийсэн байна.

Хэлэлцүүлгийн үеэр тариаланчид болон үйлдвэрлэгчид улаанбуудайн гурил импортлох асуудалд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиас гадна Хүнсний тухай, Баяжуулсан хүнсний тухай хууль болон Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний уялдаа холбоо, үр өгөөжийг харгалzan үзэж, тодорхой зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар санал гаргасан байна.

Мөн Дархан-Уул аймагт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр “Гурил үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байранд зохион байгуулсан байна.

Тус хэлэлцүүлэгт гурил үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа олон жил тогтвортой явуулж байгаа аж ахуйн нэгжийн төлөөллүүд оролцож улаанбуудайн гурил үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар өөрсдийн байр сууриа илэргийлсэн төдийгүй, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох шаардлагатай талаар саналаа хэлж, хүсэлт өгсөн байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийн хэрэгжилтийн явцад улаанбуудайн тариалалт багасаж, хурааж авах ургацын хэмжээ өмнөх оноос буурахад хүрсэн бөгөөд гурилын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа доголдон гурил, малын тэжээл, хивгийн үйлдвэрлэл 50 хувиар буурсан байна.

Энэ нөхцөл байдал стратегийн хүнс болох улаанбуудай болон гурилын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагааг тогтвортгүй болгож, тэдгээрт хийгдсэн хөрөнгө оруулалтын үр өгөөж үнэгүйдэх зэрэг эдийн засаг, нийгмийн олон сөрөг нөлөөг дагуулж байна гэж хэлэлцүүлэгт оролцогчид хэлсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд болон холбогдох албаны хүмүүс Онцгой байдлын ерөнхий газартай өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар уулзсан бөгөөд өвөлжилтийн эрсдэлийн үнэлгээ гаргаж, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төслүүд дээр хамтран ажилласан дүнд тулгуурлан малын тэжээл, үр тарианы нөөцийг дотоодын нөөц боломжийг ашиглан хангалттай хэмжээнд нөөцлөх талаар санал солилцжээ.

Түүнчлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны цахим хуудас (<https://www.mofa.gov.mn/>)-нд байршуулсан бөгөөд иргэд, олон нийтээс санал ирүүлээгүй болно.

Дээрх уулзалт, хэлэлцүүлэг болон олон нийтээс авсан санал асуулгад үндэслэн Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгож өгөх санал ирүүлсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр зардал гарахгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй, тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан.

Хуулийн хүрээнд гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурилын жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоолыг баталсан бөгөөд стратегийн ач холбогдолтой хүнс болох 1101.00.11, 1101.00.12 БТКУС-ийн кодтой улаанбуудайн дээд болон нэгдүгээр зэргийн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Улсын хэмжээнд 940 мянган тонн үр тариа тээрэмдэх суурилагдсан хүчин чадал бүхий 58 гурилын үйлдвэр, цех байгаагаас 9 нь тогтмол үйл ажиллагаа явуулж, нийт хүчин чадлын 30 хувийг ашиглаж 2024 онд 148.4 мянган тонн гурил үйлдвэрлэж, гурилын хэрэгцээний 59.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 40.9 хувийг импортоор хангасан урьдчилсан мэдээтэй байна.

Иймд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хоёр зүйлтэй байхаар боловсруулж, 1 дүгээр зүйлд Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох, 2 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгалаа.

**Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд газар тариалангийн салбарын холбоодын төлөөлөл болон газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжтэй санал солилцох уулзалтыг 2024 оны 08 дугаар сарын 01, 25-ны өдөр тус тус зохион байгуулсан.

Тус уулзалтын үеэр хуулийн хэрэгжилтийн хүрээнд тухайн өдрийн байдлаар 37.6 мян.тн улаанбуудайн гурил импортолж цаашид ч их хэмжээгээр орж ирэх хандлагатай, энэ нь цаашид улаанбуудайн тариалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй талаар санал хэлсэн.

Гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийн хэрэгжилтийн явцад улаанбуудайн тариалалт багасаж, хурааж авах ургацын хэмжээ өмнөх оноос буурахад хүрсэн бөгөөд гурилын үйлдвэрүүдийн үйл ажиллагааг доголдон гурил, малын тэжээл, хивгийн үйлдвэрлэл 50 хувиар буураад байна.

Энэ нөхцөл байдал стратегийн хүнс болох улаанбуудай болон гурилын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагааг тогтвортгүй болгож, тэдгээрт хийгдсэн хөрөнгө оруулалтын үр өгөөж үнэгүйдэх зэрэг эдийн засаг,

нийгмийн олон сөрөг нөлөөг дагуулж байна гэж хэлэлцүүлэгт оролцогчид хэлсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд болон холбогдох албаны хүмүүс Онцгой байдлын өрөнхий газартай өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар уулзсан бөгөөд өвөлжилтийн эрсдэлийн үнэлгээ гаргаж, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төслүүд дээр хамтран ажилласан дунд тулгуурлан малын тэжээл, үр тарианы нөөцийг дотоодын нөөц боломжийг ашиглан хангалттай хэмжээнд нөөцлөх талаар санал солилцжээ.

Дархан-Уул аймагт 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Гурил үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд дээрх хуулийг хүчингүй болгох шаардлагатай талаар санал хэлж, хүсэлт ирүүлсэн.

Түүнчлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны цахим хуудас (<https://www.mofa.gov.mn/>)-нд байршуулсан бөгөөд иргэд, олон нийтээс санал ирүүлээгүй болно.

Дээрх уулзалт, хэлэлцүүлэг болон олон нийтээс авсан санал асуулгад үндэслэн Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох саналыг ирүүлсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр зардал гарагүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

## УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.1-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 3.4.2.3-т “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшигийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.” гэж тус тус заасан.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно гэж заасан. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт буюу “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасны дагуу дараах үе шатаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

## НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.
- 

**Үнэлгээ хийх шалтгаан:** Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байж, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан.

Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурилын жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.” гэснийг үндэслэн 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар “Жагсаалт батлах тухай” 180 дугаар тогтоолыг мөн баталсан.

Тус хуулиар тэжээлийн хөх тариа, арвай, овьёос, царгасны буталмал болон хорголжин, хивэг, шар буурцгийн шахдас, мал, амьтны бэлдмэл болон стратегийн хүнсний нэг болох улаанбуудайн дээд болон нэгдүгээр зэргийн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Хууль хэрэгжиж эхлээд гурван сарын хугацаа өнгөрсөн мөн өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулахаар батлагдсан хууль тул хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдэх шаардлагатай гэж үзсэн.

**Үнэлгээ хийх хүрээг тогтоох:** Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Хууль тогтоомжийн үр дагаврыг судлах ажлын хүрээнд зарим зүйл заалтуудад үнэлгээ хийхээр төлөвлөсөн.

**Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгох:** “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу тогтоолын хэрэгжилтийг үнэлгээд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран “зорилгод хүрсэн түвшин”, “практикт нийцэж буй байдал” гэсэн 2 шалгуур үзүүлэлтийг сонгосон.

**Зорилгод хүрсэн түвшин:** Үнэлгээний ажлыг төлөвлөх шатны гол тулгуур хэсэг нь тухайн үнэлгээг хийх шалгуур үзүүлэлтийг тогтоох алхам бөгөөд хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний тайлангийн дүгнэлтэд үндэслэн дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

#### Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн ялгаа, онцлог

№	Шалгуур үзүүлэлт	Ойлголт, онцлог	Тайлбар
1	Зорилгод хүрсэн түвшин	Тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.	Хууль 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн. Хууль тогтоогч өвөлжилт, хаваржилтыг хүндрэл багатай даван туулах, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилтыг үзэл баримтлалдаа тодорхойлсон. Иймд хууль энэ зорилгодоо хүрч чадсан эсэхийг үнэлэх ёстой.
2	Практикт нийцэж байгаа байдал	Хууль хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.	Хуулийн ойлгомжтой байдал, амжилттай хэрэгжүүлэх боломж, бололцоо практикт байгаа эсэх зэргийг тодорхойлно.

**Харьцуулах хэлбэрийг сонгох:** Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдийг сонголоо. Үүнд:

- Хууль батлагдахаас өмнөх болон хууль батлагдсанаас хойших буюу хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хүчин төгөлдөр хэрэгжсэний дараахтай буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших буюу хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг тогтоон харьцуулна.

**Шалгуур үзүүлэлтийг томьёолох:** Шалгуур үзүүлэлтийг томьёолох хүрээнд сонгосон зүйл тус бүрийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавих бөгөөд таамаглал дэвшүүлэх болон асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томьёолох зарчим баримтлав.

**Зорилгодоо хүрсэн тувшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Шалгуур 1. Мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлснөөр зорилгодоо хүрсэн эсэх?

(Импортын хувь хэмжээ нэмэгдсэн үү эсхүл буурсан уу?)

Шалгуур 2. Улаанбуудайн дээд болон нэгдүгээр зэргийн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлснөөр зорилгодоо хүрсэн эсэх?

**Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд нийцүүлэн гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурилын жагсаалтыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу баталсан жагсаалт нь практикт нийцэж байгаа эсэх, түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарч буй үр дагавар юу вэ гэдгийг тодорхойлно.

**Мэдээлэл цуглуулах арга сонгох:** Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн тувшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, статистик мэдээлэл судлах, харьцуулалт хийх, салбарын мэргэжилтнүүдтэй уулзаж, ярилцлага, судалгааны аргаар санал авах, зэрэг ажлыг гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т заасан мэдээлэл цуглуулах аргаас дараах 2 аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно. Үүнд:

1. байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
2. холбогдох субъектээс судалгаа авах.
- 3.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хорооны статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашигласан хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар саналыг сонсож, үнэлгээ хийхэд ашиглав.

## ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны ажлын мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, салбарын мэргэжилтнээс анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлан энэхүү судалгааг гүйцэтгэв.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ доор дурдсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, судалгааны тайланг ашигласан болно. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл;
2. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль;
3. Хүнсний тухай хууль;
4. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль;
5. "Импортын барааны гаалийн татварын хувь хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоол;
6. Гаалийн ерөнхий газрын статистик тоо, мэдээлэл;
7. Үндэсний статистикийн хорооны статистик тоо, мэдээлэл;

8. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тоо, мэдээлэл.  
9.

Судалгааны анхдагч мэдээллийг ярилцлагын болон анкетын судалгааны аргаа иргэн хуулийн этгээд, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа төрийн захирагааны албан хаагчдаас авсан тул илүү бодитой, үр дүнтэй байдлыг хангаж чадна гэж үзлээ.

## ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Зорилгодоо хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн үзэл баримтлалд мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байж, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгыг тодорхойлсон. Иймд тус хуулийн зохицуулалт энэхүү үндсэн зорилгыг хангахад чиглэх юм.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.Мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлснөөр зорилгодоо хүрсэн эсэх:

Монгол Улсын Их Хурлын 1999 оны "Импортын барааны гаалийн татварын хувь хэмжээ батлах тухай" 27 дугаар тогтоолоор 10, 12, 23 дугаар бүлгийн гаалийн албан татварын хувь хэмжээг 5 хувь, 11 дүгээр бүлгийн улаанбуудайн дээд болон нэгдүгээр зэргийн гурилын гаалийн албан татварыг 15 хувь байхаар тогтоосон байна.

Хүснэгт 1. Гаалийн албан татвараас чөлөөлсөн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилын жагсаалт.

Бүлэг	БТКУС-ийн код	Барааны бичиглэл	Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоол	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай 2024.04.19
			Хувь хэмжээ	
1	1002.90.20	Хөх тария тэжээлийн		
2	1003.90.20	Арвай тэжээлийн	5	
3	1004.90.20	Овъёос тэжээлийн		0
4	1005.90.20	Эрдэнэшиш тэжээлийн		
5	1214.10.00	Царгасны (alfalfa) буталмал болон хорголж	5	
6	1214.90.90	Багсармал, хорголжин тэжээл	5	0
7	23.02	Үр тария болон буурцагт ургамлыг шигших, тээрэмдэх эсвэл бусад боловсруулалт хийх явцад гардаг, хорголжилсон эсвэл	5	0

		хорголжоогүй хивэг, үртэс болон бусад үлдэгдэл		
8	2304.00.00	Шар буурцгийн тосыг ялгах явцад гарсан, нунтагласан эсвэл нунтаглаагүй, хорголжилсон эсвэл хорголжлоогүй шаходас болон бусад хатуу хаягдал.		
9	2309.90.00	Мал, амьтны бэлдмэл тэжээл (Үүнд: муур, нохойны тэжээл багтахгүй болно.)		
10	1101.00.11	Улаанбуудайн гурил Дээд		
11	1101.00.12	Улаанбуудайн гурил I зэргийн	15	0

Төрөөс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг сайжруулах буюу Хүнсний хангамжийн тогтвортой байдлын хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдөр бүх төрлийн хүнсний будаа (цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад), ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортлоход гаалийн албан татвараас 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл чөлөөлсөн. Мөн 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр элсэн чихэр, ётон, хүнсний ургамлын тос, цагаан будааг импортлоход гаалийн албан татвараас Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал тус тус чөлөөлсөн.

УИХ-аас 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр баталсан “Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилтийн хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны “Гурил махны үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 174 дүгээр тогтоолоор дотоодын гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид 1-2 жилийн хугацаатай, 3 нэгж хувийн хүүтэй, улсын төсвөөс 10.65 нэгж хувийн хүүгийн хөнгөлөлтийг олгохоор шийдвэрлэсэн.

Дээрх тогтоолыг хэрэгжүүлэх хугацаанд Монголбанкны бодлогын хүү даруй 3 нэгж хувиар өссөн тул олгох боломжгүй болсон.

Иймд Засгийн газрын 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулах тухай” 437 дугаар тогтоолоор гурил үйлдвэрлэгчээс төлөх хүүгийн хэмжээг 6 нэгж хувь болгон нэмэгдүүлснээр 5 аж ахуйн нэгжид нийт 35.2 тэрбум төгрөгийн зээл, 3 арилжааны банкаар олгосон.

Дээрх бодлого зохицуулалтын үр дүнд дотоодын зах зээлд импортын хэт хамааралтай цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосны хангамж, үнэ харьцангуй тогтвортой байх, дотоодын гурилын үйлдвэрээр гурилын хэрэгцээг хангах нөхцөл бүрдэж, импортын хамааралтай хүнсний хангамж тогтвортой байсан.

Энэ жил цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч, зам даваа хаагдсаны улмаас хүнсний тээвэрлэлт доголдох нөхцөл байдал үүссэн. Монгол Улсын нийт өрхийн 32 хувь нь орон нутагт амьдарч байгаа ба үүнээс 81.5 хувь малчин болон малтай өрх ба хөдөөгийн хүн амын дунд мах, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ нь бусад төрлийн хүнсийн харьцуулахад өндөр байдаг.

“Практикт нийцэж байгаа байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Монгол Улс 2024 оны ургац хураалтын дүнгээр нийтдээ 386.4 мянган улаанбуудай хураан авсан ба үүнээс 160 орчим мян.тн улаанбуудайг гурилын үйлдвэрт нийлүүлсэн байна.

Монгол Улсын жишсэн хүн амын тоо 2024\* онд 2.799.2 мянга болно гэж тооцвол 106.3 мян.тн гурил, 191.3 мян.тн гурилан бүтээгдэхүүн хэрэгцээтэй бөгөөд нийт хүн амын хэрэгцээнд 230.0 мян.тн гурил буюу 320.0 мян.тн улаанбуудай шаардлагатай байна .

Гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, нөөцийг харгалzan жилийн нийт хэрэгцээний 10 хүртэл хувь буюу 25.0 мян.тн улаанбуудайн гурилыг Монгол Улсын хилийн боомт бүхий аймгуудаар гаалийн албан татваргүй импортлохоор тооцоо судалгааг хийсэн.

Хүснэгт 2. Мал, амьтны тэжээл, тэжээлийн бэлдмэл 2024 оны 12-р сарын импортын гүйцэтгэл. (кг/мян.ам доллараар)

Хэсгийн код болон нэр	Бүлгийн код болон нэр	Барааны код	Барааны нэр	Нэгж	Импорт
					2024 оны 12 сар
					Тоо/кг
02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	10 Yр тариа	1002	Хөх тариа	кг	240,000
02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	10 Yр тариа	1003	Арвай	кг	1,544,454
02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	10 Yр тариа	1004	Овьёос	кг	18,732,196
02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	10 Yр тариа	1005	Эрдэнэ шиш	кг	1,044,428
04 Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	23 Хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл ба хаягдал; малын тэжээлийн бэлдмэл.	2302	Багсармал, хорголжин тэжээл	кг	87,349,250
04 Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	23 Хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл ба хаягдал; малын тэжээлийн бэлдмэл.	2304	Шар буурцгийн бусад хатуу хаягдал.	кг	6,448,540
04 Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	23 Хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл ба хаягдал; малын тэжээлийн бэлдмэл.	2309	Мал, амьтны бэлдмэл тэжээл.	кг	2,501,000

Нийт дүн

117.859.868

Гэвч Монгол Улсын Их хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан хуулиар гурилын импортын гаалийн албан татварыг чөлөөлсөнтэй холбоотой хилийн боомтуудаар орж ирж байгаа гурилын хэмжээ эрс нэмэгдэж жилийн эцсийн байдлаар нийт 64.2 мян.тн улаанбуудайн гурил импортолсон байгаа нь анх тооцоолсноос дариу 3 дахин их гүйцэтгэлтэй байна.

Үүнээс: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар босмтоор 35.9 мян.тн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор 14.1 мян.тн, Увс аймгийн Боршоо боомтоор 10.3 мян.тн, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт, Завхан аймгийн Арцсуурь боомтоор 3.9 мян.тн улаанбуудайн гурилыг Оросын Холбооны Улсаас тус тус имортолсон ба эдгээрийн 40.4 мян.тн нь улаанбуудайн дээд гурил, 23.8 мян.тн нь улаанбуудайн I зэргийн гурил байна.

Хууль батлагдахаас өмнө буюу 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн статистик мэдээгээр улаанбуудайн 1 кг-аар савласан дээд гурилын үнэ 2969 төгрөг, I зэргийн гурил 2426 төгрөг байсан ба 2024 оны 12 дугаар сарын байдлаар дээд гурил 3207 төгрөг, I зэргийн гурил 2323 төгрөг буюу дотоодын үйлдвэрийн гурилын үнэ буураагүй байна.

Гурилын үнэ 75 гаруй хувь нь улаанбуудай, 25 орчим хувь нь бусад зардал болох сав баглаа боодол, тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдол, ажиллах хүч, эрчим хүч, ус, дулааны зардлаас хамаардаг ба тухайн жилийн улаанбуудайн үнийн өсөлт нь дараа жилийн гурилын үнэд нөлөөлдөг.

Улсын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж буй 9 гурилын үйлдвэрийн агуулахад шинэ ургацаас 160 мянган тн улаанбуудай, 22 мянган тн гурил буюу жишсэн хүн амын 170 хоногийн хэрэглээ хадгалагдаж байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний Зөвлөлийн 2023 оны "Монгол Улсын 2023 онд экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний нэр төрөл, тоо хэмжээний тухай" 01 дүгээр зөвлөмжөөр импортлох улаанбуудайн гурилын тоо хэмжээг 20.0 мян.тн-оор тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад зөвлөмж болгосон бөгөөд гурил үйлдвэрлэгч 9 аж ахуйн нэгжид 20.0 мян.тн гурил экспортын зөвшөөрлийг олгосон.

Улаанбуудайн гурил 2023 онд гурилын импортын нийт хэмжээ 11,2 мян.тн, гурилан бүтээгдэхүүн 23,5 мян.тн, 2024 оны эхний хагасын байдлаар 23,1 мян.тн гурил, 11 мян.тн гурилан бүтээгдэхүүн импортолсон байна.

Нийт нутгийн 80 гаруй хувьд нь цасан бүрхүүл тогтох ихэнх нутгаар хүйтний эрч чангарч, мал аж ахуйн салбарын хаваржилт хүндэрч, мал сүрэг өвс тэжээлийн дутагдалд орж, малчид ихээхэн хохирол амсах эрсдэл үүсээд байсан цаг үед хаваржилтыг хохирол багатай даван туулахад малын өвс, тэжээлийн нөөц хангамжийг нэмэгдүүлэхэд 100-200 мян.тн өвс, 385-412 мян.тн нэмэгдэл тэжээл шаардлагатай бөгөөд нийт тэжээлийн 55 орчим хувийг дотооддоо үйлдвэрлэн нийлүүлж, үлдсэн хэсгийг импортлон авах нөхцөл үүсээд байсан.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулахад шаардлагатай нийт тэжээлийн 55 орчим хувийг дотооддоо үйлдвэрлэн нийлүүлж, үлдсэн хэсгийг импортоор авахаар тооцоо, судалгааг хийсэн ба мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлснөөр Монгол Улсын хилээр 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 117.9 мян.тн буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэг дахин их мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг имортолсон байна.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг хийллээ.

Баяжүулсан гурил болон мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийн хангамжийг сайжруулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс Гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, нөөцийг харгалзан жилийн нийт хэрэгцээний 10 хүртэл хувь буюу 25.0 мян.тн улаанбуудайн гурилыг импортлохоор тооцоо судалгааг хийсэн боловч хууль батлагдсанаас хойш импортын тоо хэмжээ эрс нэмэгдэж 64.2 мянган тн гурил импортолсон байна.

Анх тооцоолсноос дариу 3 дахин илүү гүйцэтгэлтэй мөн тогтмол үйл ажиллагаа явуулж буй гурилын үйлдвэрийн улаанбуудайн үлдэгдэл их, гурил үйлдвэрлэлийн хэмжээ нь 28 хувиар буурах урьдчилсан тооцоолол зэргийг харгалзан үзэж хууль зорилгодоо хүрсэн тул хуулийг хүчингүй болгох шаардлагатай байна.

Хууль хэрэгжиж эхлээд 3 сарын хугацаанд Монгол Улсын хилээр 2024 оны хагас жилийн гүйцэтгэлээр 117.9 мян.тн буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэг дахин их мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг имортолсон, 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 64.2 мян.тн улаанбуудайн гурил имортолсон байгаа нь анх тооцоолсноос дариу 2-3 дахин илүү гүйцэтгэлтэй байна.

Хууль батлагдахаас өмнө буюу 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн статистик мэдээгээр улаанбуудайн 1 кг-аар савласан дээд гурилын үнэ 2969 төгрөг, I зэргийн гурил 2426 төгрөг байсан ба 2024 оны 12 дугаар сарын байдлаар дээд гурил 3207 төгрөг, I зэргийн гурил 2323 төгрөг буюу дотоодын үйлдвэрийн гурилын үнэ буураагүй байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд гурил болон гурилан бүтээгдэхүүний үнэ буурахад нөлөөл байхгүй мөн Оросын Холбооны Улсаас импортоор авч буй зарим гурилын чанар хангалттай түвшинд хүрэхгүй, малын тэжээлийн нөөцийг дотоодын үйлдвэрлэлээр бэлтгэх бололцоотой зэргийг харгалзан үзэж дээрх хуулийг хүчингүй болгох шаардлагатай байна.

### Зөвлөмж

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй” гэж заасан тул Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох.

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

**НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөлд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын<sup>2</sup> 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийнэ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Гурав.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах; хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Дөрөв.Үр дүнг үнэлэх;
5. Тав.Дүгнэлт, зөвлөмж өгөх.
- 6.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл нь дараах бүтэцтэйгээр боловсруулагдсан байна:

-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох талаар;  
-Хуулийг дагаж хугацааг мөрдөх хугацааны талаар.

**ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ  
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

"**Зорилгод хүрэх байдал**" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдсан болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн болоод хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзэж хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авлаа.

"**Хүлээн зөвшөөрөгдөх байдал**" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана.

<sup>1</sup> Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт албан ёсоор хэвлэгдсэн.

<sup>2</sup> Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

Хуулийн төсөлд холбогдох этгээдүүдээс ирүүлсэн санал, талуудын байр суурийг тандах байдлаар уг шалгуур үзүүлэлтэд тохиорох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хуулийг дагаж мөрдөх этгээдүүд хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэх боломжтой байх гэж үзэж энэхүү шалгуур үзүүлэлт сонгосон болно.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**“Зардал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг тооцон судална.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана.

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

## ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Үнэлгээний ажлын энэ хэсэгт аргачлалд заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг сонгох буюу тогтоож, өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлттэй үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тохируулан үнэлэхэд бэлтгэх юм. Эдгээр үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг сонгоходоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа буюу голлох ач холбогдолтой, үзэл баримтлалын буюу зарчмын шинжтэй, мөн анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож авсан болно.

Өөрөөр хэлбэл, тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ товч бөгөөд оновчтой байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг, хууль зүйн үр дагавар бий болгож буй, агуулгын хувьд чухал ач холбогдолтой, мөн асуудал дагуулах магадлалтай, анхаарах шаардлагатай заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судлан үнэлэх болно. Шалгуур үзүүлэлт бүрийн хүрээнд үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тоймловол:

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хүснэгтийн дагуу тогтоолоо. Үүнд:

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	<p>Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.</p> <p>Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд шалгах.</p>
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг	<p>Хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авна. Хуулийн төсөл З зүйлтэй./</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.</p>
3.	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн тусlamжтайгаар тогтоо юм. хуулийн төслийн тодорхой зүйл, заалт, зохицуулалтыг бус төслийг бүхэлд нь сонгон авч үнэлэх нь зүйтэй. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь энэхүү шалгуур үзүүлэлтээр үнэлэх юм. Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

### ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль

тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

#### **4.1.ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл:

-Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах, мал амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийн хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр нэмэгдүүлэх, үнийн хөөрөгдлөөс сэргийлэх;

-Хүнсний үйлдвэрлэлийн тэр дундаа гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хадгалж, дэмжиж нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх.

Дээр дурдсан зорилтыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

**-Зорилт-1.** Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлөх хугацааг тодорхой болгож хуулийн үйлчлэх хугацааг дуусгавар болгох:

-Энэ зорилтын хүрээнд мал, амьтны тэжээл үйлдвэрлэл, газар тариалангийн салбар, тогтмол үйл ажиллагаа явуулж буй 9 гурилын үйлдвэрийн үйл ажиллагааг тогтворжуулах, улаанбуудай, гурилын дотоодын нөөцийг нэмэгдүүлнэ.

#### **4.2. “ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ:**

“Тодорхой хугацаанд практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг тодруулахыг зорьлоо.

Хуулийн төслийг эцэслэн боловсруулснаар тодорхой заасан хугацаанд практикт хэрэгжих боломж бүрдэнэ.

#### **4.3.“ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг шалгах үүднээс судлаачийн зүгээс хуулийн төслийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

##### **4.3.1. Хуулийн зохицуулах харилцааны хувьд:**

Татварын ерөнхий хуулийн З дугаар зүйлийн 3.1-д “татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй” гэж заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар зохицуулахаар тусгасан.

##### **4.3.2. Хуульд хэрэглэсэн нэр томьёоны хувьд:**

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөлд “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” шаардлага тавигддаг.

Баяжуулсан гурил болон мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг импортоход холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан удирдамж, стандарт, журмыг баримтална.

#### 4.3.3. Найруулгын хувьд:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан. Үүнд:

Хүснэгт 2 Шалгах хуудас

№	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1.	29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай <u>уялдсан</u> байх;	Уг шаардлагыг хангасан байна.
2.	29.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан байна.
3.	29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
4.	29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
5.	29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
6.	29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
7.	29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
8.	29.1.8. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
9.	29.1.9. шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт	хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг тусгасан.
10.	29.1.10. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад хууль хүчингүй болсонд тооцох тухай	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

	дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх.	
11.	29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	

#### Хүснэгт 3. Шалгах хуудас

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.</b>		
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Энэ шаардлагад нийцэж байна.	
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.	
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.	
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.	
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.	

#### 4.4.“ХАРИЛЦАН УЯЛДАА” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хүчин төгөлдөр бусад хууль тогтоомжтой болон өөр хоорондоо, Монгол Улсын бусад хууль тогтоомжтой харилцан уялдаж нэгдмэл болж чадаж байгаа эсэх асуудлыг тогтоох юм.

Хуулийн төсөлд хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацааны талаар тодорхой тусгасан байна.

#### Хүснэгт 4. Шалгах хуудас

№	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
4	Хуулийн төслийн зүйл, заалт төслийн бусад заалттай нийцэж байгаа эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулийн заалттай нийцсэн эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
6	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
7	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

8	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
9	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
10	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Хуулийн төсөлд тухайн асуудал хөндөгдөөгүй
11	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
12	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал хөндөгдөөгүй
13	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хуулийн төсөл нь хүний эрхийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
14	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
15	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
17	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд тухайн асуудал хөндөгдөөгүй

## ТАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судлаачийн зүгээс Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэх ажиллагааг хийлгээ.

Хуулийн төслийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалыг чанд баримтлан, аргачлалд заасан дараах шалгуур үзүүлэлтийг сонгон авч, уг шалгуур үзүүлэлтийг илтгэх зүйл, хэсэг, заалт бүрийг үнэлэв. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал;
- Практикт хэрэгжих боломж ;
- Ойлгомжтой байдал;
- Харилцан уялдаа.

Хуулийн төсөлтэй холбоотой санал, дүгнэлтийг шалгуур үзүүлэлт бүрийн хэсэгт тодорхой дэлгэрэнгүй бичсэн бөгөөд түүнийг дараах байдлаар хураангуйлан тоймлож байна.

Хуулийн төслийн Гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль зорилгодоо хүрсэн тул тус хуулийг хүчингүй болгооор тусгасан байна.

Хуулийн төслийн уялдаа холбоог хангах, бусад хуультай нийцүүлэх, нэр томьёог жигдлэх, боловсруулалтыг сайжруулах талаарх саналыг “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд гаргаж тодорхой бичсэн болно.

--ooOoo--

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРДАС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ  
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардлыг тооцож, цаашид ачааллыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

<b>Хуулийн төслийн 1,2 дугаартай зүйлтэй холбоотойгоор хуулийн этгээдээс гарах зардал</b>	
<b>Гүйцэтгэх ажил, үйлчилгээ</b>	<b>Нэгж</b>
Энэхүү хуулттай танилцах, судлах	10 минут
Шинэ хуулийн мэдээлэл цуглуулах	10 минут
Татварын тайланд тусгах	60 минут
<b>Нийт</b>	<b>80 минут</b>
ААНБ-ын ажиллагчдын сарын голч цалин	1,556,400 төгрөг
ААНБ-ын ажиллагчдын <b>дундаж минутын цалин</b>	<b>147 төгрөг</b>
<b>Ажлын хөлс</b>	<b>11,790 төгрөг</b>
<b>Үйлдвэрлэгчдийн тоо</b>	<b>10</b>
<b>Тоон узүүлэлт</b>	<b>1</b>
<b>Давтамж</b>	<b>Байхгүй</b>
<b>Нийт зардал</b>	<b>117,600 төгрөг</b>

### 1.Хуулийн этгээдийн зардал

Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр үйлдвэрлэсэн гурил, мал, амьтны тэжээл үйлдвэрлэгч болон импортлогч **хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд хамааралтай ба хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцлоо.**

### Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Гаалийн статистик

\*Хуанлийн жилд давтамжтайгаар хийх ажил байхгүй.

Энэ хууль хуулийн этгээдэд ачаалал бага гарах тул энэхүү зардлыг бууруулах боломж байхгүй. Хууль батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх нийт зардал 117,600 төгрөг байна.

### 2.Иргэний зардал

Иргэн энэ хуульд заасан Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр гурил, мал, амьтны тэжээл үйлдвэрлэгч болон импортлогч тул хууль хэрэгжихтэй холбоотой зардал гарахгүй.

### 3.Төрийн байгууллагын зардал

<b>Төрийн байгууллагууд</b>	<b>Гүйцэтгэх ажил, үйлчилгээ</b>	<b>Нэгж</b>
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Энэ хууль батлагдсаны дараа хуулийг холбогдох төрийн байгууллага, аж ахуй нэгжүүдэд хүргэж мэдээллээр хангах, сурталчлан таниулах	Мэдээллийг бэлтгэх 480 минут /1 өдөр/
	Холбогдох байгууллагууд ад хүргүүлэх	480 минут /1 өдөр/
Татварын ерөнхий газар	Улсын хэмжээнд хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих	1440 минут /3 өдөр/

<b>Нийт</b>	<b>2,400 минут</b>
Төсөвт байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин	<b>1,752,100 төг</b>
	<b>165.9 төг</b>
Төсөвт байгууллагад ажиллагчдын <b>дундаж минутын цалин</b>	
<b>Ажлын хөлс</b>	<b>398 160 төгрөг</b>
<b>Хамрагдагчдын тоо</b>	<b>1 хүн</b>
<b>Тоон үзүүлэлт</b>	<b>1</b>
<b>Давтамж</b>	<b>Байхгүй*</b>
<b>Нийт зардал</b>	<b>398,160 төгрөг</b>

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

\*Хуанлийн жилд давтамжтайгаар хийх ажил байхгүй

Хууль батлагдсанаар төрийн байгууллагад ачаалал нь 2400 минут буюу **398,160 төгрөг** байна.

#### Дүгнэлт

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог батлагдсан аргачлалын дагуу хийхэд:

- Хуулийн этгээдийн зардал 117,600 төгрөг;
- Иргэний зардал 0 төгрөг;
- Төрийн байгууллагын зардал 398,160 төгрөг.

Нийт 515,760 төгрөгийн зардал гарах тооцоо гарч байна.

--ooOoo--



ХУНС ХЕДЭС АЖ АХҮЙ.  
ХӨЛТӨН ЧИЛДЭРЭЙН ЯАМ

EXCELSIOR

Сохранили память техническим наставником

БАССЕЙН УРСИНХУЛ

VOLUME 13, NUMBER 1

3800, HISTOIRE DU TOON

卷之三

卷之三

卷之三

卷之三

Газийн элбэгтэвараас чөгөөлж  
тухайг хүчинчний болсцад  
тооцух тухайг хүчинчний төслийд дсан болжсан.

98076515. Н-мн-  
заслнч-спасн-9-3-2-1-  
бандр 214 тснг БЕДРО  
телефоннн-гвард, Утац  
десн

三國志

## ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ

Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй, тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан.

Уг хуулиар улаанбуудайн гурил болон малын тэжээл, тэжээлийн нэмэлтийн хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлж, тогтворжуулахаар импортын гаалийн албан татварыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс чөлөөлсөн.

Хуулийн хэрэгжилтийн явц болон Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг олон нийтээр дараах байдлаар хэлэлцүүлсэн болно.

Шинэ ургацын улаанбуудай хурааж авах улиралтай холбогдуулан 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр газар тариалангийн салбарын холбоодын төлөөлөлттэй санал солилцох уулзалтыг зохион байгуулсан.

Тус уулзалтын үеэр дээрх хуулийн хэрэгжилтийн хүрээнд тухайн өдрийн байдлаар 37.6 мян.тн улаанбуудайн гурил импортолж цаашид ч их хэмжээгээр орж ирэх хандлагатай байгаа талаар энэ нь цаашид улаанбуудайн тариалалтад сөргөөр нөлөөлж болзошгүйг холбооны гишүүд санал хэлсэн.

Мөн Дархан-Уул аймагт 2024 оны 08 дугаар сарын 25-ны өдөр газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 30 гаруй аж ахуй нэгжүүдийн төлөөлөлтэй уулзаж ургац хураалт, техникийн шинэчлэл болон “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд малчдын бэлтгэж буй өвч тэжээлийн бэлтгэлийг эрчимжүүлэх зэрэг өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүллээ.

Хэлэлцүүлгийн үеэр тариаланчид болон үйлдвэрлэгчид улаанбуудайн гурил импортлох асуудалд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиас гадна Хүнсний тухай, Баяжуулсан хүнсний тухай хууль болон УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний уялдаа холбоо, үр өгөөжийг харгалzan үзэж, тодорхой зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаа санал гаргасан.

Гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийн хэрэгжилтийн явцад энэ оны улаанбуудайн тариалалт 56 мян.га буюу 15 хувиар багасаж, хурааж авах ургацын хэмжээ өмнөх оноос 20 хувиар буурахад хүрсэн бөгөөд гурилын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа доголдон гурил, малын тэжээл, хивгийн үйлдвэрлэл 50 хувиар буураад байна. Энэхүү нөхцөл байдал нь стратегийн хүнс болох улаанбуудай болон гурилын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагааг тогтвортгүй болгож, тэдгээрт хийгдсэн хөрөнгө оруулалтын үр өгөөж үнэгүйдэх зэрэг эдийн засаг, нийгмийн олон сөрөг нөлөөг дагуулж байна гэж хэлэлцүүлэгт оролцогчид хэлж байлаа.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд болон холбогдох албаны хүмүүс Онцгой байдлын ерөнхий газартай өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар уулзалт хийсэн. Энэ жилийн өвөлжилтийн эрсдэлийн үнэлгээ гаргаж, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хамтран ажиллах төсөл болон малын тэжээл, үр тарианы нөөцийг дотоодын нөөц боломжийг ашиглан хангалттай хэмжээнд нөөцлөн ажиллах тал дээр санал солилцсон.

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТОЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

№	Овог нэр	Албан тушаал	Мэйл хаяг	Утас
1	Жадамбын Энхбаяр	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	enkhbayar@mofa.gov.mn	99117928
2	Цэндгомбын Болорчулун	Ман яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга	bolorchuluun@mofa.gov.mn	99105090
3	Д.аваасүрэнгийн Довчинсүрэн	Мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	dovchinsuren@mofa.gov.mn	99118715
4	Хурцаагийн Цэрэнханд	Мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Хүнсний үйлдвэрийн салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн	tserenkhand@mofa.gov.mn	99076515